

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр, Мягмар гараг*

**Хуралдааны тэмдэглэлийн агуулга**

**Хуралдааны товч тэмдэглэл:** 1-7

**Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:** 8-14

---

1. “Шүүгчийн орон тоог батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл 1-9

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/ 9-12

3. Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/ 12-14

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы  
Хууль зүйн байнгын хорооны  
05 дугаар сарын 28-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 26 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Г.Амартүвшин, Б.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: Ш.Раднаасэд;

Тасалсан: Э.Бат-Амгалан, С.Бямбацогт, Л.Мөнхбаатар, Ц.Мөнх-Оргил, Ж.Сүхбаатар.

Хуралдаан 11 цаг 27 минутаас 14 цаг 52 минутад завсарлав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг хойшлуулах горимын санал гаргав.

**Д.Цогтбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Нэг. “Шүүгчийн орон тоог батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Байнгын хорооны дарга Д.Цогтбаатар “Шүүгчийн орон тоог батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Д.Цогтбаатар:** “Шүүгчийн орон тоог батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 5

Бүгд: 11

54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Эрдэнэбулган, мөн газрын шинжээч Ж.Амгалан, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Алтанцэцэг, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

### **1.Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Д.Цогтбаатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 39 дэх хэсгийн “сонгуулийн сурталчилгааны” гэсний өмнө “нэгээс илүү сувагтай радио, телевизийн” гэж нэмж, 37 дахь хэсгийн “нэр дэвшигч оролцсон” гэсний дараах “эсхүл” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

## **2.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Д.Цогтбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	3
Бүгд:	11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

## **3.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл**

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Д.Цогтбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	6
Бүгд:	11

45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Д.Цогтбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалангийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Д.Цогтбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

**4.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл**

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Д.Цогтбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

**5.Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл**

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Д.Цогтбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

**6.Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл**

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Д.Цогтбаатар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр, томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 15 цаг 11 минутад хэлэлцэж дуусав.*

**Гурав.Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Эрдэнэбулган, мөн газрын шинжээч Б.Алтантуяа, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч А.Энх-Эрдэнэ, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын дарга Ж.Аюуш, Гадаадын иргэн, харьяатын газрын Иргэний харьяаллын газрын дарга Г.Билэгт, Оюуны өмчийн газрын Хяналт шалгалтын хэлтсийн дарга Л.Гантулга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Б.Галсанбат нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал танилцуулав.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Д.Цогтбаатар:** Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 6  
Бүгд: 11  
45.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Д.Цогтбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Д.Цогтбаатар:** Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг дэмжиж, чуулганы нэгдсэн

хуралдаанаар оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 5  
Бүгд: 11  
54.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 15 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 30 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 15 цаг 21 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ХУУЛЬ ЗҮЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Жанжсин Д.Сүхбаатар”  
танхим  
11 цаг 26 минут.

### ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Д.Цогтбаатар:** Хууль зүйн байнгын хорооны хурлаа эхэлж байна. Хүрэлцэн ирсэн гишүүдэд талархал илэрхийлье. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул ХЗБХ-ны 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. Ирц Дамдины Цогтбаатар, Ширнэнбаньдын Адьшаа, Норовын Алтанхуяг, Борхүүгийн Дэлгэрсайхан, Цэрэнжамцын Мөнхцэцэг, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Ням-Осорын Учрал, Баттөмөрийн Энхбаяр, Бямбасүрэнгийн Энх-Амгалан гэсэн гишүүдийн ирцтэйгээр хурал эхэлж байна. Ингээд Байнгын хорооны хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал 1.Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар нарын 4 гишүүн 2024 оны 5 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн хууль, анхны хэлэлцүүлэг. 2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх, ЗГ-аас 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдөр

өргөн мэдүүлсэн хууль, анхны хэлэлцүүлэг. 3.ХЗДХ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах хуулиудын хуулиудыг боловсронгуй болгох зорилгоор боловсруулсан холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, ЗГ-аас 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх. 4.Шүүгчийн орон тоог шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл гэсэн ийм 4 асуудал өнөөдрийн хуралд хэлэлцүүлэхээр төлөвлөгдөж орсон байгаа.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүд байна уу? Би тэгвэл өөрөө энэ дээр нэг санал хэлэх хэрэгтэй байна. Ингээд 4 асуудал байгаа. Байнгын хорооны даргын хувьд нэг асуудлыг гишүүдээсээ хүлцэл өчөөд нэг асуудлыг эндээс өнөөдөртөө татан авах шаардлагатай байна. Яагаад гэвэл хэлэлцүүлгийн явцад бас ганц, хоёр дахин ажлын хэсэг дээр ярих асуудлууд гарч байгаа учраас энийг татан авч байна. 1 дүгээр асуудал энэ Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд гэсэн энийг өнөөдрийн хуралдаанаас би аваад, дараагийн хуралдаанд оруулъя гэсэн саналтай байна. Энэ дээр саналтай гишүүд байна уу?

Хуралдаан 11 цаг 27 минутаас 14 цаг 52 минутад завсарлав.

Ингээд түр завсарласан ХЗБХ-ны хурлаа эхлүүлж байна. Тэгээд түрүүн яг санал хураах дээр зогссон байгаа. Хэлэлцэх асуудлаас 1 дүгээр асуудлыг хасья гэсэн юу санал оруулсан байгаа. Тэгээд энэ асуудлаар санал хураалтаа явуулъя, хасахыг дэмжье гэсэн томъёолоор. 54 хувиар санал дэмжигдлээ. Ингээд, тэгвэл ингээд иүүд 2 дугаар асуудлаасаа эхлээд явна.

**Нэг. “Шүүгчийн орон тоог батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

2 дугаар асуудал руугаа орёе. Шүүгчийн орон тоог шинэчлэн батлах тухай хууль Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье. Энэ чинь шүүгчийн, Шүүгчийн орон тоог тэгэхээр шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан энэ юуг тогтоолыг боловсруулсан байгаа. Тогтоолын төслийг та бүгдэд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрээ өгнө үү? Алга байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү? Алга байна.

Шүүгчийн орон тоог шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж батлуулах нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 54,5 хувиар санал дэмжигдлээ. Тогтоолын төсөл.

Ингээд энийг Шүүгчийн орон тоог шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Мөнхцэцэг танилцуулна. Ганбат гишүүн. Сандаг-Очир гишүүн аягүй их юман дээр тавигдаад явж байгаа. Энх-Амгалан гишүүн танилцуулъя.

14.56 цаг

**Хоёр.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.21-ний**

**өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

3 дугаар асуудалдаа орёе. ЗГ-аас 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцэж байгаа хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Энэ үү? Ажлын хэсгийг танилцуулъя. Н.Мягмар ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, Г.Эрдэнэбулган ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, энэ хүмүүсээ оруулаарай. Ж.Амгалан ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын шинжээч, Д.Бат-Эрдэнэ Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга гэсэн ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байна. Хүмүүсээ оруулаарай, ажлын хэсгийнхэн сая нэр дуудсан хүмүүсээ оруулаарай. Ингээд хуралдаанд оролцож байгаа албаны хүмүүсийг танилцууллаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцэж эхэлье.

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Энэ чинь юу, ингээд энэ хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан саналаар санал хураалт явуулъя. 1 саналтай байгаа. Нэг.Зөрчлийн тухай хуульд

нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх санал. 1.Төслийн 1 дүгээр зүйлийн 39 дэх хэсгийн “сонгуулийн сурталчилгааны” гэсний өмнө “нэгээс илүү сувагтай радио, телевизийн” гэж нэмж, 37 дахь хэсгийн “нэр дэвшигч оролцсон” гэсний дараах “эсхүл” гэснийг хасах. Хоёр 6 дугаар зүйлийн доор. Энэ саяын уншиж танилцуулсан томъёоллоор санал хураалт явуулъя. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Ингээд цаашаа үргэлжлүүлээд явъя. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй саналгүй. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй саналгүй. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал байхгүй. Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй саналгүй. Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Хуулийн зүйлийн 6 дугаар зүйл дээр нэг санал байгаа. Төслийн 6 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6 дугаар зүйл.энэ хуулийг 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” энэ томъёоллоор санал хураалт явуулъя. 66,6 хувиар санал дэмжигдлээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Зарчмын зөрүүтэй, байхгүй байна. Зарчмын зөрүүтэй санал нэг санал байгаа юу тийм ээ. Зарчмын зөрүүтэй саналыг танилцуулъя. Төслийн 2 дугаар

зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” энэ томъёоллоор санал хураалт явуулъя. 72,7 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан саналаар санал хураалт явуулъя. Нэг саналтай байгаа. Энэ дээр, тийм үү тэгвэл байхгүй юм байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй саналгүй.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нь нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Энд нэг санал байгаа. Саналыг танилцуулъя. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал хураалт. Манайхан, Энх-Амгалан гишүүн саналаа өгөөгүй байна. Энэ санал уначихлаа. Энх-Амгалан гишүүний микрофоныг өгье.

**Б.Энх-Амгалан:** Сая миний энэ аппарат ажилласангүй. Саяын санал хураалтыг хүчингүй болгож өгөх горимын санал гаргаж байна.

**Д.Цогтбаатар:** Саяын саналыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 63,6 хувиар санал дэмжигдлээ. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн нэрсээ өгнө үү? Сая юу санал, түрүүний санал хураалт хүчингүй боллоо. Ингээд түрүүн би томъёоллыг уншиж танилцуулсан тэр томъёоллоор санал хураалт явуулъя, дэмжье гэсэн томъёоллоор. 54,5 хувиар түрүүн уншиж танилцуулсан санал дэмжигдлээ.

Дараагийн хууль руугаа оръё. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй саналгүй. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан саналаар санал хураалт явуулъя, 1 саналтай байгаа. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ. Энэ саналыг саяын уншиж танилцуулсан саналыг дэмжигдсэн саналыг гишүүн Цогтбаатар гаргасан байгаа.

Төрийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй саналгүй байна.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан саналаар санал хураалт

явуулъя, 1 саналтай байгаа. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл.энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан гишүүн Цогтбаатар. Санал хураалт. 54,5 хувиар санал дэмжигдлээ.

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье. Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Алга байна. Зарчмын зөрүүтэй саналгүй. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй саналгүй. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Зарчмын зөрүүтэй саналгүй.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан саналаар санал хураалт явуулъя. 1 саналтай байгаа. Төслийн 4 дүгээр зүйлд доор дурдсан өөрчлөн, Төслийн 4 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4 дүгээр зүйл.энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” Санал гаргасан гишүүн Цогтбаатар. Санал хураалт. 63,6 хувиар санал дэмжигдлээ.

Хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдийн бичгээр гаргасан найруулгын санал 1 байна. Энийг би уншиж танилцуулъя. Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр, томъёо, хэл найруулга, дэс

дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал хураалт саяын уншиж танилцуулсан томъёоллоор дэмжье гэж. 66,6 хувиар санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсантай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай бол болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сэргэлэн гишүүн танилцуулчихъя. Өнөөдөр биш байх, одоо би хэлж мэдэхгүй байна. Өнөөдөр юм уу, маргааш л байгаа. Сэргэлэн гишүүн.

15.11 цаг

**Гурав.Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор холбогдуулан боловсруулсан хуулийн төслүүд /Засгийн газар 2024.05.21-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/**

Дараагийн асуудалдаа оръё. Энэ чинь 3 дугаар асуудал. ЗГ-аас 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулиудыг боловсронгуй болгох зорилгоор боловсруулсан холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Хүмүүсээ оруулаарай. Г.Эрдэнэбулган ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга, Энх-Эрдэнэ ХЗДХЯ-ны Бодлогын

хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч, Алтантуяа хууль зүйн, ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын шинжээч, Л.Нямдаваа Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга, Ж.Аюуш Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газрын дарга, Г.Билэгт Гадаадын иргэн, харьяатын газрын Иргэний харьяаллын газрын дарга, Л.Гантулга Оюуны өмчийн газрын Хяналт шалгалтын газрын дарга. Ингээд ийм бүрэлдэхүүнтэйгээр, манай Байнгын хорооноос ХЗБХ хариуцсан нарийн бичгийн дарга Ариунтунгалаг гэсэн ийм бүрэлдэхүүнтэйгээр ажлын хэсэг оролцож байна.

Төсөл санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, ЗГ-ын гишүүн Учрал танилцуулна. Учрал гишүүний микрофоныг өгье.

**Н.Учрал:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-ын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэлтэй шийдвэрт хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн үр дүнгийн тайлан, хуулиар тусгайлан эрх олгосон заалтын судалгааны дүн, цаашид авах арга хэмжээний тухай хэлэлцээд ЗГ төрийн захиргааны төв байгууллага, төрийн захиргааны байгууллагад тус тус эрх олгогдсон заалтыг 2 дахин багасгах чиглэлийг баримтлан, холбогдох хуулийн төслийг боловсруулж, танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан.

Уг захирамжийг хэрэгжүүлэх зорилгоор ХЗДХ-ийн сайдын 2024 оны А/03 дугаар тушаалаар ХЗДХ-ийн салбарын хууль тогтоомж, дүрэм журамд хяналт шинжилгээ хийж, холбогдох хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсэг байгуулагдан ажиллалаа. Дэд ажлын хэсэг нь ХЗДХ-ийн салбарт хамаарах 35 хууль тогтоомжоор эрх олгосон 160 гаруй заалт, түүний дагуу

баталсан дүрэм журамтай нэг бүрчлэн танилцаж, хяналт шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах багцын хүрээнд 26 хууль, 65 журмыг холбогдох хуулиар зохицуулагдах ёстой гэж үзэн хуулийн төслүүдийг боловсрууллаа.

Эдгээрээс Галт зэвсгийн хууль нь олон тооны журмын зохицуулалтыг хуульд тусгах шаардлагатай байгаагаас нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлбэрээр бичих боломжгүй болсон тул хуулийн шинэчилсэн найруулгын хэлбэрээр төслийг боловсрууллаа. Дээрх хуулийн төсөлд Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу үзэл баримтлалыг тусад нь тодорхойлж, холбогдох үнэлгээ, судалгааг хийлээ.

ХЗДХ-ийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах Хууль зүйн туслалцааны тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай, Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай зэрэг 7 хуульд 25 эрх олгосон заалтын дагуу баталсан журмыг нэмж тусгах, хуулийн төслүүдийг Хүний эрхийг хангах багц хуулийн төслүүдтэй хамтран боловсруулж байна. Ингэснээр ХЗДХ-ийн салбарт ЗГ-ын 2023 оны 48 дугаар тэмдэглэлээр өгсөн захиргааны хэм хэмжээний актыг 2 дахин бууруулах чиглэлд 90 журмаар зохицуулж байгаа харилцааг хуульд тусгахаар төслийг боловсрууллаа.

Хуулийн төслүүдийн талаар 1-д Харьяатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 2-т Оюуны өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 3-д Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 4.Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 5.Архив,

албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 6.Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 7.Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 8.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 9.Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 10.Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 11.Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 12.Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, 13.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 14.Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 15.Гэрээт харуул хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 16.Хувийн хамгаалалтын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 17.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 18.Нөхөрлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, 19.Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 20.Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 21.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулахдаа, зохицуулах хуульд өөрчлөлт оруулах тухай, 22.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 23.Төрийн албаны, Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 24.Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, 25.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд багтаж байна.

Хуулийн төслүүдийг олон нийтийн санал авах зорилгоор Хууль тогтоомжийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсэгт заасны дагуу ХЗДХЯ-ны албан цахим хуудсанд байршууллаа. Түүнчлэн төрийн

захиргааны төв, шүүх эрх мэдэл, эрдэм шинжилгээ, судалгааны болон төрийн бус олон нийтийн 38 байгууллагад санал авахаар хүргүүлж, саналуудыг авч, төслүүдэд тусгасан болно. Та бүхнийг дэмжиж өгөхийг хүсье. Баярлалаа.

**Д.Цогтбаатар:** Учрал сайдад баярлалаа. Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан төсөл санаачлагчаас асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд асуулт асууж дууслаа. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан гишүүд асуулт асуух, үг хэлэх дуусаж байна.

Ингээд санал хураалт явуулъя. Засгийн газраас 2024 он, 2024 оны 5 дугаар сарын 21-ний өдөр өргөн мэдүүлсэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах сүүлийн, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулиудыг боловсронгуй болгох зорилгоор боловсруулсан холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Байж байгаарай, хэн бэ? Учрал сайд өөрөө асуудлаа танилцуулаад, энэ чинь саналаа өгөөгүй байх юм. Учрал сайдын микрофоныг өгье.

**Н.Учрал:** Энэ сая саналаа өгсөн чинь эсрэг гарчихлаа. Дахиж хураалгаж өгөөч.

**Д.Цогтбаатар:** Саяын санал хураалтыг хүчингүй болгоё гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 54,5 хувиар санал дэмжигдлээ. Ингээд түрүүний санал хүчингүй боллоо. Одоо түрүүн уншиж танилцуулсан томъёоллоор саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 54,5 хувиар санал дэмжигдлээ. Хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд

хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулна.

15.21 цаг

Байнгын хорооны хуралдаан, Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ талархъя.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

